



НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 09 сарын 04 өдөр

Дугаар А/249

Улаанбаатар хот

Улаанбаатар шинэ бүтээн байгуулалт ХХК-ны эргэлтийн хөрөнгийг балансаас балансад шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолоор батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.3 дахь хэсэг, 5 дугаар зүйлийн 5.2 дахь хэсэг, Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын даргын 2024 оны А/82 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Үндсэн хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2024 оны 08 дугаар сарын 28-ний өдрийн 7 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Эргэлтийн бус хөрөнгийн дансанд нийт 21,666,467.40 (хорин нэгэн сая зургаан зуун жаран зургаан мянга дөрвөн зуун жаран долоон төгрөг дөчин мөнгө) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хөрөнгийг хавсралтын дагуу шилжүүлж, данс бүртгэлээс хасахыг Улаанбаатар шинэ бүтээн байгуулалт ХХК (Г.Мишээлт)-д зөвшөөрсүгэй.

2.Шилжин ирсэн хөрөнгийг нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн дагуу данс бүртгэлдээ бүртгэн авахыг Нийслэлийн Өмчийн харилцааны газрын Ахлах нягтлан бодогч (Т.Оюунтуул)-д үүрэг болгосугай.


3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Өмчийн хяналт, ашиглалт, дотоод аудитын хэлтэс (Г.Тэмүүжин)-т даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



В.ОЮУМАА

Нийслэлийн Өмчийн харилцааны газрын
даргын 2024 оны 09 дугаар сарын 09-ны
өдрийн 2/14 дугаар тушаалын хавсралт



Балансаас балансад шилжүүлэх хөрөнгийн жагсаалт

Байгууллагын нэр: Улаанбаатар шинэ бүтээн байгуулалт ХХК

№	Эд хогшлын нэр	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Ашиглалтад авсан он	Нэгж үнэ	Нийт үнэ	Үлдэх өртөг
1	Макет	ш	2	2022	3,080,000.00	3,080,000.00	3,080,000.00
2	Тосон халаагуур	ш	2	2017	3,054,694.50	6,109,389.00	458,130.40
3	Уртасгагч залгуур	ш	1	2019	2,688,094.50	2,688,094.50	178,022.58
4	Хангарьд хаяг	ш	2	2019	2,932,769.45	5,865,538.90	388,460.02
5	Хогийн сав	ш	1	2019	2,746,445.00	2,746,445.00	181,900.50
6	Номын тавиур	ш	1	2018	1,177,000.00	1,177,000.00	549,032.20
Нийт шилжүүлэх хөрөнгийн дүн					15,679,003.45	21,666,467.40	4,835,545.70